

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV Байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ОЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ДАРГА Г.ЦАГААНХҮҮ ТАНАА

2021.02.25 № 07/529
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын аалагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 13 зорилтын хүрээнд 119 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 70 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд 50 нэрийн 52,024.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасахдаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллаагүй.

\\10.10.10.27\Bichig_Khened\Yawsan_Bichig\2021\0225audit\1-2-R_Gazar62.Docx

0*1051055

Ойн судалгаа хөгжлийн төв нь тендерийн хэмнэлт 40,614.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр шууд гэрээ байгуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	835,309,261.35	1,026,650,826.52
33	АВЛАГА	7,884,800.00	12,810,340.42
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	3,587,059.42
335	Бусад авлага	7,884,800.00	9,223,281.00
3351	Байгууллагаас авах авлага	7,884,800.00	9,223,281.00
35	БАРАА МАТЕРИАЛ	827,424,461.35	1,013,840,486.10
351	Түүхий эд материал	67,393,425.25	21,022,450.00
35110	Тусгай зориулалттай материал	67,393,425.25	21,022,450.00
354	Хангамжийн материал	760,031,036.10	992,818,036.10
35410	Бичиг хэргийн материал	-	356,000.00
35470	Бусад хангамжийн материал	760,031,036.10	992,462,036.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,133,566,669.61	9,134,605,726.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,133,566,669.61	9,134,605,726.72
392	Биет хөрөнгө	1,968,127,336.31	2,962,757,726.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	147,090,630.00	699,199,430.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,277,933.24)	(124,718,466.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,992,587,211.38	1,877,908,377.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(586,817,063.12)	(769,045,642.34)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	907,723,607.71	1,219,772,700.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(516,267,705.88)	(472,193,137.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,783,729.33	34,245,336.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,582,222.77)	(17,909,723.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,926,710.00	618,967,068.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(37,039,627.10)	(103,468,217.22)
393	Биет бус хөрөнгө	6,165,439,333.30	6,171,847,999.94
39301	Програм хангамж	14,247,000.00	14,247,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,413,666.70)	(11,000,000.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,159,606,000.00	6,168,601,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,968,875,930.96	10,161,256,553.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,968,875,930.96	10,161,256,553.24

51	Засгийн газрын хувь оролцоо		
		8,968,875,930.96	10,161,256,553.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,696,476,268.14	6,696,476,268.14
51101	Өмч: - төрийн	6,696,476,268.14	6,696,476,268.14
512	Хуримтлагдсан үр дүн		
		2,196,905,276.63	3,389,953,031.91
51210	Өмнөх үеийн үр дүн	2,238,018,957.63	2,197,572,409.63
51220	Тайлант үеийн үр дүн	(41,113,681.00)	1,192,380,622.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	75,494,386.19	74,827,253.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,968,875,930.96	10,161,256,553.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,988,979,670.00	5,181,087,864.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,421,770.00	1,448,871,808.50
120	Нийтлэг татварын бус орлого	29,421,770.00	1,448,871,808.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,421,770.00	1,448,871,808.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,031,770.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,390,000.00	7,376,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,441,495,608.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,959,557,900.00	3,732,216,056.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,957,882,900.00	3,525,088,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,957,882,900.00	3,525,088,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,675,000.00	207,127,356.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	1,675,000.00	197,227,356.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,900,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,622,995,623.47	3,988,707,242.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,622,995,623.47	3,988,707,242.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	670,599,713.94	2,349,563,554.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,584,793.91	332,279,599.16
210101	Үндсэн цалин	120,087,540.91	278,262,653.99
210102	Нэмэгдэл	56,197,253.00	48,146,094.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,300,000.00	5,870,851.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,283,258.00	46,933,308.23
210201	Тэтгэврийн даатгал	15,825,914.00	31,672,485.23
210202	Тэтгэмжийн даатгал	1,864,338.00	3,798,370.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,491,469.00	3,038,695.00
210204	Ажилгүйдлийн даатгал	372,868.00	749,743.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,728,669.00	7,674,015.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	18,542,699.00
210301	Гэрэл цахилгааны зардал	-	11,176,519.00
210302	Түлш, халаалтын зардал	-	7,366,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,897,924.30	58,884,598.07
210401	Бичиг хэрэг	8,410,950.00	4,038,920.00
210402	Тээвэр, шатахуун	7,556,400.00	49,838,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,505,374.30	3,677,578.07
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,425,200.00	1,330,000.00
2105	Нормативт зардал	-	2,850,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,850,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,400,000.00	1,420,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	1,420,000.00
210604	Урсгал засвар	7,400,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	36,518,800.00	-
210702	Дотоод албан томилолт	36,518,800.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,210,880.00	1,459,339,649.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,673,280.00	1,458,727,236.00
210803	Даатгалын үйлчилгээ	792,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	587,200.00	612,413.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	158,400.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	366,704,057.73	429,313,701.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,891,600.00	6,133,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	363,812,457.73	423,180,201.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,952,395,909.53	1,639,143,687.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,053,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	35,053,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,952,395,909.53	1,604,090,087.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,215,168.55	46,432,242.12
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,906,180,740.98	1,557,657,845.25
2200	Дотоод эх үүсвэрээр	4,906,180,740.98	1,557,657,845.25
223001	Бусад хөрөнгө	4,906,180,740.98	1,557,657,845.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>365,984,046.53</u>	<u>1,192,380,622.28</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	<u>407,097,727.53</u>	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,397,727.53	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	401,700,000.00	
6	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(41,113,681.00)</u>	<u>1,192,380,622.28</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>6,010,532,950.00</u>	<u>3,743,592,256.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,421,770.00	11,376,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,421,770.00	11,376,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,421,770.00	11,376,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,031,770.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,390,000.00	11,376,200.00
120009	Бусад орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,981,111,180.00	3,732,216,056.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,957,882,900.00	3,525,088,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,957,882,900.00	3,525,088,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,228,280.00	207,127,356.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	197,227,356.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,417,500.00	9,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,810,780.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>291,452,775.49</u>	<u>2,285,344,842.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	291,452,775.49	2,285,344,842.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,237,606.94	2,200,271,940.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,754,192.00	310,643,809.05
210101	Үндсэн цалин	109,103,163.00	209,458,421.51
210102	Нэмэгдэл	42,804,900.00	67,272,635.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,846,129.00	33,912,752.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,174,700.00	44,907,680.74
210201	Тэтгэврийн даатгал	14,398,700.00	32,658,032.74
210202	Тэтгэмжийн даатгал	1,694,000.00	3,036,005.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,355,200.00	2,409,829.00
210204	Ажилгүйдлийн даатгал	338,800.00	602,483.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,388,000.00	6,201,331.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	23,891,180.00
210301	Гэрэл цахилгааны зардал	-	16,525,000.00
210302	Түлш, халаалтын зардал	-	7,366,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,095,834.94	59,355,531.07
210401	Бичиг хэрэг	6,145,450.00	4,554,920.00
210402	Тээвэр, шатахуун	6,916,400.00	49,838,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,608,784.94	3,542,511.07

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,425,200.00	1,420,000.00
2105	Нормативт зардал	2,845,600.00	2,850,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,845,600.00	2,850,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,820,000.00	1,420,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,420,000.00	1,420,000.00
210604	Урсгал засвар	7,400,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,364,400.00	-
210702	Дотоод албан томилолт	3,364,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,450,880.00	1,750,120,239.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,873,280.00	1,749,507,826.60
210803	Даатгалын үйлчилгээ	792,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	627,200.00	612,413.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	158,400.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,732,000.00	7,083,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,732,000.00	7,083,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,215,168.55	85,072,901.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	35,053,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		35,053,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,215,168.55	50,019,301.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,215,168.55	46,432,242.12
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,587,059.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,719,080,174.51</u>	<u>1,458,247,414.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,719,080,174.51	1,458,247,414.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,719,080,174.51	1,458,247,414.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,719,080,174.51	1,458,247,414.00
223001	Бусад хөрөнгө	4,552,611,774.51	1,458,247,414.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,166,468,400.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,719,080,174.51)</u>	<u>(1,458,247,414.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,870,268.14	-	990,870,406.56	1,527,740,674.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,870,268.14	-	990,870,406.56	1,527,740,674.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	75,494,386.19	-	75,494,386.19
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	6,159,606,000.00	-	-	6,159,606,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,879,994,914.30	2,879,994,914.30
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	75,494,386.19	2,196,905,276.63	8,968,875,930.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	667,133.00	667,133.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,696,476,268.14	75,494,386.19	2,197,572,409.63	8,969,543,063.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(667,133.00)	-	(667,133.00)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	1,192,380,622.28	1,192,380,622.28
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,696,476,268.14	74,827,253.19	3,389,953,031.91	10,161,256,553.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,614,658,500.00	3,490,032,657.67	(124,625,842.33)	96.6
УРСГАЛ ЗАРДАЛ	2,156,022,800.00	2,031,785,243.67	(124,237,556.33)	94.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,089,668,700.00	1,996,731,643.67	(92,937,056.33)	95.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,043,100.00	197,284,588.31	(1,758,511.69)	99.1
Үндсэн цалин	120,451,500.00	119,505,958.51	(945,541.49)	99.2
Нэмэгдэл	64,441,600.00	64,441,600.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	14,150,000.00	13,337,029.80	(812,970.20)	94.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,870,800.00	26,587,604.90	(283,195.10)	98.9
Тэтгэврийн даатгал	18,909,100.00	18,625,904.90	(283,195.10)	98.5
Тэтгэмжийн даатгал	1,990,400.00	1,990,400.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,592,300.00	1,592,300.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	398,100.00	398,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	3,980,900.00	3,980,900.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,992,800.00	7,991,180.00	(1,620.00)	100.0
Гэрэл, цахилгаан	625,000.00	625,000.00	-	100.0
Түлш, халаалт	7,367,800.00	7,366,180.00	(1,620.00)	100.0
Хангамж, бараа материалын зардал	15,339,000.00	15,324,531.07	(14,468.93)	99.9
Бичиг хэрэг	4,555,800.00	4,554,920.00	(880.00)	100.0
Тээвэр, шатахуун	5,807,100.00	5,807,100.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,550,500.00	3,542,511.07	(7,988.93)	99.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,425,600.00	1,420,000.00	(5,600.00)	99.6
Нормативт зардал	2,851,200.00	2,850,000.00	(1,200.00)	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,851,200.00	2,850,000.00	(1,200.00)	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,425,600.00	1,420,000.00	(5,600.00)	99.6
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,425,600.00	1,420,000.00	(5,600.00)	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,834,052,400.00	1,743,190,239.39	(90,862,160.61)	95.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,832,468,400.00	1,742,577,826.39	(89,890,573.61)	95.1
Даатгалын үйлчилгээ	792,000.00	-	(792,000.00)	00.0
Тээврийн хэрэгслийн татвар	633,600.00	612,413.00	(21,187.00)	96.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	158,400.00	-	(158,400.00)	00.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,800.00	2,083,500.00	(10,300.00)	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,800.00	2,083,500.00	(10,300.00)	99.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,354,100.00	35,053,600.00	(31,300,500.00)	52.8
Бусад урсгал шилжүүлэг	66,354,100.00	35,053,600.00	(31,300,500.00)	52.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	66,354,100.00	35,053,600.00	(31,300,500.00)	52.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,458,635,700.00	1,458,247,414.00	(388,286.00)	100.0
Бусад хөрөнгө	1,458,635,700.00	1,458,247,414.00	(388,286.00)	100.0

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,614,658,500.00	3,490,032,657.88	(124,625,842.12)	96.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,614,658,500.00	3,478,656,457.88	(136,002,042.12)	96.2
Улсын төсвөөс санхүүжих	3,614,658,500.00	3,478,656,457.88	(136,002,042.12)	96.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	11,376,200.00	11,376,200.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,376,200.00	11,376,200.00	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	12	12	0	100
Удирдах ажилтан	2	1	-1	50
Гүйцэтгэх ажилтан	10	11	1	110
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12	12	0	100
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	0	0	0	
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	0	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		207,127,356.00
УРСГАЛ ЗАРДАЛ		207,127,356.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		203,540,296.58
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		113,359,220.74
Үндсэн цалин		89,952,463.00
Нэмэгдэл		2,831,035.00
Унаа хоолны хөнгөлөлт		20,575,722.74
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		18,320,075.84
Тэтгэврийн даатгал		14,032,127.84
Тэтгэмжийн даатгал		1,045,605.00
ҮОМШӨ-ний даатгал		817,529.00
Ажилгүйдлийн даатгал		204,383.00
Эрүүл мэндийн даатгал		2,220,431.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		15,900,000.00
Гэрэл, цахилгаан		15,900,000.00
Хангамж, бараа материалын зардал		44,031,000.00
Тээвэр, шатахуун		44,031,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,930,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,930,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		5,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		5,000,000.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,587,059.42
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3,587,059.42
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		207,127,356.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		207,127,356.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Г.Цагаанхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд авлага барагдуулах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт зохион байгуулахгүй байх, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Даваадорж аудитор, Цэрэнхүү нар хэрэгжүүлэв.

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Ойн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулахад шаардлагатай мэдээллийг шинжлэх ухаан, техникийн дэвшилтэд арга технологид тулгуурлан ойн тогтвортой хөгжлийг хангахуйцаар боловсруулж бүрдүүлэх, ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд өөрийн чиг үүргийн дагуу оролцоход оршино.

Ойн судалгаа хөгжлийн төв УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал:

- Мод, сөөгний үрийн дээжид шинжилгээ хийх, ойн шилмэл үрийн нөөц бүрдүүлэх, хадгалах, худалдан борлуулах;
- Монгол оронд ургадаг модлог ургамлын цуглуулгын цэцэрлэгт хүрээлэнгийн үйл ажиллагаа эрхлэх;
- Ойн тооллого, ойн зохион байгуулалтын ажлын тайланг нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, сэдэвчилсэн зураг боловсруулах;
- Ойжуулалтын ажлын зураг төсөл хийх, таримал ойг улсын ойн санд хүлээн авах эсэх талаар дүгнэлт гаргах;
- Хууль бус мод бэлтгэл, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа бусад арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих;
- Ойн хөнөөлт шавж, өвчний голомтын судалгаа хийж, дүгнэлт гаргах;
- Ойн тооллого, ой зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих;
- Ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах болон ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, сургалт, хяналт хийх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-ын 9 дүгээр хавсралт “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”
- Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,030,093.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 120,601.9 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,988,707.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 79,774.1 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,192,380.6 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	7,884.8	12,810.3	4,925.5
Бараа материал	827,424.4	1,013,840.5	186,416.1
Үндсэн хөрөнгө	8,133,566.7	9,134,605.7	1,001,039.0
Нийт хөрөнгө	8,968,875.9	10,161,256.5	1,192,380.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,968,875.9	10,161,256.5	1,192,380.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,968,875.9	10,161,256.5	1,192,380.6

Бараа материалын дансны үлдэгдэл 1,013,840.5 мянган төгрөг болж 186,416.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 435,225.5 мянган төгрөгийн материал худалдан авсан, үнэ төлбөргүй 5,715.3 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал хүлээн авсан, төсөл хөтөлбөрөөс 20,951.0 мянган төгрөгийн материал шилжүүлэн авч, 275,475.7 мянган төгрөгийн материал зарцуулснаас тус тус шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,134,605.7 мянган төгрөг болж 1,001,039.0 мянган төгрөгөөр өссөн нь “Ногоон хэрэм” төслөөс үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,669,058.3 мянган төгрөгийн, худалдан авсан 9,389.9 мянган төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдлээр 35,159.3 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А-1/1653 дугаар бүхий зөвшөөрлөөр акталсан 132,565,3 мянган төгрөгийн, дахин үнэлгээний хорогдлоор 269,066.1 мянган төгрөгийн, шилжиж ирсэн хөрөнгийн элэгдлийн зардал 310,937.1 мянган төгрөгөөр тус тус хасагдсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 6,051,810.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,437,152.0 мянган төгрөгөөр бууруулж 3,614,658.5 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төлөвлөлт бодитой боловсруулаагүй байгааг харуулж байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,478,656.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 11,376.2 мянган төгрөг, нийт 3,490,032.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,031,785.2 мянган, хөрөнгийн зардалд 1,458,247.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж 46,432.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,490,032.6 мянган төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь урсгал зардлыг 124,237.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 388.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөл хөтөлбөрөөс 197,227.3 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 9,900.0 мянган, нийт 207,127.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 113,359.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 18,320.1 мянга, гэрэл, цахилгааны зардалд 15,900.0 мянга, тээвэр, шатахууны зардалд 44,031.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 5,000.0 мянга, эрхийн бичиг хэвлүүлэх зардалд 6,930.0 мянга, нийт 203,540.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3,587.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 38 мэдээллээс хугацаандаа оруулсан 31 мэдээлэл, хугацаа хоцроосон 6 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,900.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг 50.6 хувиар, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	7,900.0	0.5	4,000.0	0.5	3,900.0	50.6
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Зөвлөмж	3	7,400.0	1	7,400.0	-	-	100.0
Нийт дүн	5	15,300.0	2.5	11,400.0	0.5	3,900.0	83.5

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 107,972.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 92,638.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 15,333.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 107,972.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 92,638.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. ТӨБЗГ-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А-1/1653 дугаар бүхий зөвшөөрлөөр 48 нэрийн 45,148.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах, ТӨБЗГ-ын 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 497 дугаар бүхий зөвшөөрлөөр 6,876.5 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг тракторыг үндсэн хөрөнгийн данснаас хасахдаа ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Ойн судалгаа хөгжлийн төв нь тендерийн хэмнэлт 40,614.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2-т "төлөвлөсөн төсөл арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 15,333.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Өмнөх оноос дамжиж ирсэн Үндэсний ойжилт ХХК-иас авах 3,884.8 мянган төгрөгийн, тайлант онд үүссэн Төв аймгийн Лүн сум дахь Мод үржүүлгийн газраас авах 5,348.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд 6,100.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээний бусад зардал гарсан нь Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолын 3.4-д "Төсвийн урсгал зардлаас дараах санхүүжилтийг түр зогсоох", 3.4.4-д "Бараа үйлчилгээний бусад зардал" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	ОСХТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/309/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Он дамжиж ирсэн болон тайлант онд үүссэн авлагыг барагдуулаагүй	9,233.3	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Г.Цагаанхүү П.Оюунгэрэл
2	Тайлант онд үр ашиггүй бараа үйлчилгээний бусад зардал гаргасан	6.100.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Г.Цагаанхүү П.Оюунгэрэл
3	Акталсан болон данснаас хасагдсан үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлээгүй	52,024.9	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Г.Цагаанхүү П.Оюунгэрэл
4	Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээнд шууд гэрээ байгуулсан	40,614.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Г.Цагаанхүү П.Оюунгэрэл
	ДҮН	107,972.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 41/А0160056
САГ-2021/309/СТА-ТШЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ойн судалгаа хөгжлийн төв нь 48 нэрийн 45,148.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахдаа, 6,876.5 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг тракторыг данснаас хасахдаа ТӨБЗГ-ын тогтоолоор батлагдсан холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 6.5-д “ТӨБЗГ-ын шийдвэрээр эд хөрөнгийг акталж, худалдахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчит хуулийн өмч хамгаалах байнгын зөвлөлөөс худалдах ажлыг зохион байгуулна. Хөрөнгө акталж, худалдах шийдвэрт үнийг заасан бол түүнээс багагүй үнээр, худалдах үнийг заагаагүй бол өмч хамгаалах байнгын зөвлөлөөс үнийг тогтоож, худалдах ажлыг зохион байгуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийг данснаас хасах, актлахдаа холбогдох журмыг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын дарга Г.Цагаанхүү, нягтлан бодогч П.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

143.18.18.20\Bilg_Ahreg\Alban_Shaardlaga\2021\02\kshin 2-R_Gaar22.Docx

001081090



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 42/АД160056
САГ-2021/309/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ойн судалгаа хөгжлийн төв нь тендерийн хэмнэлт 40,614.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлээгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцожгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, “45.2.2-т “төлөвлөсөн төсөл арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу төсөл, арга хэмжээг зохион байгуулж байх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Ойн судалгаа хөгжлийн төв” УТҮГ-ын дарга Г.Цагаанхүү, нягтлан бодогч П.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

А.ДАВААДОРЖ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26430

\\10.10.20\audit_khreeglahon\baandagi\2021\0225\audin 2-R\Gant 23.docx

001081092

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing.